



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/193/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn "Ариун төгс оршихуй аудит" ХХК-ийн Ахлах аудитор: Ч.Сэлэнгэ Утас: 99023656 Цахим хаяг: ariuntugsorshihuiaudit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.21 № 42

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Чиглэл батлах тухай" 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу багш, байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 163,262.2 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 18,748.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандив болон бусад эх үүсвэрээс 118,558.2 төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагчийн 21 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 54 арга хэмжээг 100 хувь, 5 арга хэмжээг 85.7 хувь буюу нийт дүнгээр 98 хувиар биелүүлж биелэлтийг хүргүүлсэн боловч дээд байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

• 07020187

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	109,937.50	226,598.10
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	688,460.70	733,854.90
Нийт хөрөнгийн дүн	798,398.20	960,453.00
Нийт өр төлбөрийн дүн	-	1,186.20
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	798,398.20	959,266.80
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	798,398.20	960,453.00
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,764,343.70	1,194,492.30
Үйл ажиллагааны зардлын дүн	965,945.50	1,033,623.70
Үйл ажиллагааны үр дүн	798,398.20	160,868.60
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	798,398.20	160,868.60
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		798,398.20
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		
Тайлант оны үр дүн	798,398.20	160,868.60
Эцсийн үлдэгдэл	798,398.20	959,266.80
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	909,629.60	1,061,545.60
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	869,988.20	926,158.40
Үйл ажиллагааны ЦМГ	39,641.40	135,387.20
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-21,472.00	-34,083.00
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	18,169.40	101,304.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18,169.40
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,169.40	119,473.60
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	959,381.10
Урсгал зардал	-	918,236.60
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,060,685.30
Улсын төсвөөс санхүүжих	-	892,807.80
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	160,612.50
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	7,265.00
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	119,473.60

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 16.4 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Монголын цахилгаан холбоо ХК-тай байгуулсан гэрээний дагуу 15.4 сая төгрөгийг шилжүүлж, зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.
- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 1.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй зөрчил илрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1		-	-
	НИЙТ	1	1	-	-	1		-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,